

Архангай аймгийн Газрын албанаас "Ногоон Алт" хотолбор, Газрын харилцаа, геодези, зураг зvйн газартай хамтран "Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг толовлож хэрэгжvүлэх нь" сэдэвт сургалт семинарыг 2008 оны 5 сарын 5-6-ны өдрvүдэд Цэцэрлэг хотод зохион байгуулж Архангай аймгийн бvх сумын засаг дарга, газрын даамал, 213 бэлчээр ашиглалтын хэсгийн ахлагч болон ГХГЗЗГ, аймгийн удирдлага, тосол, хотолборvүдээс нийт 300 гаруй хvн оролцлоо.

Сургалтын эхний одор онгорсон жилийн бэлчээрийн газрын товллолт, товллогооний хэрэгжилт болон цаашид энэ ажилд малчид болон бусад талуудын оролцоо ямар байх талаар хэлэлцсэн бол дараагийн одор нь "Ногоон алт" хотолбор хэрэгжиж буй Их Тамир сумын туршлагатай танилцлаа. Мон Их Тамир суманд шинээр байгуулагдаж буй "Сарлагийн хооврийн сургалт-vйлдвэрлэлийн тов"-ийн нээлтэнд оролцож, бэлчээр сайжруулах талаар хийж буй туршилтууд, малчдын бэлчээр ашиглалтын хэсгvүдийн vйл ажиллагаа, сумын тvвшинд бэлчээрийн хамтын менежментийн vйл ажиллагаа хэрхэн зохион байгуулагдаж байгаатай газар дээр нь танилцан харилцан саналаа солилцсон юм.

Их тамир сумын Бугат багийн "Ишгэнт" хэсгийн бэлчээрийг товллогоотэй сэлгэж, онжоож ашиглаж байгаа болон хадлангийн газрыг хашиж хамгаалснаар арвин хадлан бэлтгэхийн зэрэгцээ цаг хvндэрсэн вед нооц бэлчээр болгон ашиглаж буй туршлагууд нь оролцогчдод шинэ санаа, урам зориг огсон vйл ажиллагаа болсон юм.